



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

106 дугаар байр, Найрамдалын гудамж 1,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442878, 70442891

Цахим шуудан: emg@bayankhongor.moh.gov.mn

2024. 02. 02 № 16-16-02/074/04

Барилгын зурагт эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

ЦЭСДА ХХК-с ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Рашаант 10 дугаар багт баригдах "Политехникийн коллежийн 150 хүүхдийн дотуур байр"-ын барилгын ажлын зурагт Эрүүл ахуй тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/02 дугаар удирдамж болон холбогдох стандарт, норм дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахаар 2024 оны 01 дүгээр сарын 29-2 дугаар сарын 02-ны өдрүүдэд эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийлээ.

Барилга байгууламжийн зориулалт:

Барилгын зургийг "ЦЭСДА" ХХК гүйцэтгэсэн. Шифр: ЦЭ-11-06-08-200/23

Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/54 тоот захирамжтай, 26483 метр квадрат хэмжээтэй, 6409007920 нэгж талбарын дугаартай, боловсролын байгууллага зориулалтаар олгосон байна.

Уг барилга байгууламж нь ногоон байгууламж, авто машины зам талбайтай. Барилга нь 3 блок, үндсэн блок нь 3 давхар 18м*18м хэмжээтэй, А, Б блок 15м*27.2м хэмжээтэй 2 давхар, зоорьгүй.

Ус хангамж, бохир ус зайлуулалтын байдал: Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдох "Чандмань-Баянхонгор" ХК-ний 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 09/2023 дугаартай техникийн нөхцөлтэй. Хэрэглээний халуун усыг ус халаагчаар төлөвлөсөн. Гал тогоонд тос баригч төлөвлөсөн.

Дулаан хангамж, агаар сэлгэлтийн байдал: "Маралгүн" ХХК-ний 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дулаанаар хангах техникийн нөхцөлтэй. Халаах хэрэгсэлд ширмэн радиатор төлөвлөсөн.

Хоолны заал, халуун боловсруулалтын хэсэгт агаар өгөх болон соруулах системтэй. Өрөөнүүдэд ердийн болон механик агааржуулалтын системтэй. Ариун цэврийн өрөөнд агаар сорох механик системтэй.

Инженер геологийн судалгаа: Инженер геологийн судалгааны ажлыг "Топ гео техник" ХХК гүйцэтгэсэн. Хөрсний ус 4м гүнд илэрсэн. Элсэн чигжээстэй хайрган ул хөрстэй.

Дээрх байдлыг үндэслэн ДҮГНЭХ нь:

Барилга байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгэхэд эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй.

Цаашид авах арга хэмжээ:

1.Цэвэр усны шугамд цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсний дараа, хангагч байгууллагын зөвшөөрөл авч төвийн шугамд холбох, техникийн туршилт хийх,

2.Ариун цэврийн өрөөний шалны төвшин бусад өрөөний шалнаас -2,5-3 см доошоо сууж, хаягдал усны трамп хийхээр төлөвлөн, гүйцэтгэх.

Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхийн хүрээнд:

Doc.dugnelt2023

642319064

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана./, 14.2 дахь /Улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг дээд шатны улсын байцаагч хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно./

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ *Ц.Урангоо* Ц.УРАНГОО



ХҮЛЭЭН АВСАН:
АРХИТЕКТОР *[Signature]* Т.БИЛГҮҮНБОЛД